

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Боть ХХХХ (463)

2016

(01-06)

ШААЗГАЙ АЛАГ ТОЛЬ ¹

Б. Ринчен

Хувьсгалын өмнөх монгол-гадаад, гадаад-монгол хоёр, гурван, дөрвөн буюу таван хэлний толь, хоёр хэлний тайлбар толь, зүйл хуваасан толь гэх зэргийн толь байсан нь цөм монгол эрдэмтний зохиосон зүйл байжээ.

Өдгөө монголын ард түмэн азийн соёлын хүрээнээс бидэнд шинэ болох европын буюу герег-латин соёлын хүрээнд орсон үес урдын азийн соёлын хүрээний тэдгээр толийн зүйл, европод шинэ соёлын хүрээний зүйл болох азийн соёлын хүрээний утга соёлыг судлахад тун чухал зүйл байгааг олон улсын дорнодахины судлалын эрдэмтэн нэгэн зэргээр үнэлэн үздэг байна. Үүнд орос, англи, герман, франц зэргийн хэлнээ европ-азийн, ази-европын хэлний олон толь гарсаар, манай монгол-ази, ази-монгол хэлний толийн үг нэрийг дүйлгэн үзэхэд монгол хэлний хэдэн түмэн үг, даруй европын орос, англи, герман, франц хэлний үгтэй сайхан оноосон зүйл бий болох нөхцөл бүрдэж, орчин үеийн шинжлэх ухааны аргаар зохиосон сайн монгол-европ, европ-монгол толь, тухайлбал, орос-монгол, монгол-орос толь хийхэд дөхөмтэй болж байна. Мөн орчин үеийн олон ухааны зүйлээс мэдвээс зохих зүйлийг бүртгэсэн монгол нэвтэрхий толь зохиоход ч энэ завсар олон улсын эрдэмтний судлан оноосон ази-европ, европ-азийн толиос ази-монгол, монгол-азийнхаа толийн үгийг тулган түүж, ямар монгол үг европын хэлний ямар үгтэй дүйдгийг мэдэж авах нь дөхөм болж байна. Үүнд ганц нэгэн жишээ дурдвал, монгол хэлнээ вайдурьяа, биндурьяа, бидерья гэдэг нэрийг монгол-санскрид толиор хөөж үзвэл, санскрид вайдурья болж, түүнийг энэтхэг-европ толинд үзвэл, санскрид-орос толиноо даруй берилл гэсэн чулууны нэр болдог байна. Замбага гэдэг цэцгийн нэрийг монгол энэтхэг толиор үзээд, энэтхэг нэрийг нь энэтхэг-европ толиор хөөн үзэхэд, даруй санскрид-орос толинд магнолия гэдэг мод цэцгийн нэр болдог байна.

Манай туйл гэдэг үгийг монгол-азийн толинд сайхан оноосон зүйл бий. Түүнийг европ хэлээр юу гэсэн үг болохыг проф. Ошанины 1955 онд гарсан хятад-орос сайн толинд үзвэл, бүх утгыг нь гаргасан нь: в высшей степени, крайне, крайний, очень гэсэн

¹ Академич Бямбын Ринчен аугайн бичсэн тус өгүүллийг МУИС-ийн багш, манжич Ц.Шархүү (1940-1986)-гийн машиндсан эхээс авч, үг, үсгийн ямар нэгэн засвар оруулалгүй нийтэлж байна. 1970 онд бичсэн энэ өгүүлэл үүнээс урьд нийтийн хүртээл болж байсан эсэхийг үл мэднэ. Гэвч, академичийн бүтээлийг сайн мэдэх хүмүүсээс сурж, бүтээлийнх нь эмхтгэлүүдээс шүүн үзсэний эцэст, юутай ч эдүгээ ийм өгүүлэл байдгийг нь өргөн олон, хэлбичгийн салбарынхан үзэж дуулаагүй нь лавтай байх тул, та бүхнээ сонордуулах нь зүйтэй гэж үзэв.

нь туйлын сайхан гэдэг маань даруй очень красиво, очень красивый, туйлын үнэтэй – крайне дорого, крайне дорогой гэх мэт болно. Бас предал, лимит, архи-, максимальный, полярный, кульминационный, конец, сугубый, последний гэх зэргээр тодорхойлжээ. Жишээ нь: туйлын хугацаа–крайний срок, последний срок, мэдцийн туйл–предел знаний гэх мэт жишээтэй. Ингэж монгол үгийг монгол–ази толинд оноосон нь ази–европын толийн оноолттой дүйлгэхэд, нэг монгол үг маань дэлхий нийтийн олон хэлэнд бусад боловсон улсын хэлний үгтэй нэгэн адил авалцаатай болж, аль ч хэлэнд нэгэн адил оноон орчуулах, зөрөөгүй мэдэлцэх замд орох учиртай болж байна. Иймд орчин үеийн монгол–гадаад, гадаад–монгол толь зохиоход дэлхий нийтийн эл зарчмыг баримтлах ёстой болж байгаа цаг болно. Орчин үеийн монгол–гадаад буюу гадаад–монгол хэлний толийн сайн муу нь энэ зарчимд нийцсэн эссэнээс болно. Үүнд эс нийлбэл, толь хийгээч хүний мэдлэг дулимаг болсны гэрч тэмдэг даруй мөн болно.

Энэ зарчмаар хөөн үзэхэд, япон, солонгос, вьетнам, хятад нийтээр нангиад үсгийг өөр өөрийнхөө дуудлагаар дуудан буй. Үүнд япон хэлний “шокудоо” гэдэг үгийг хятадаар “шитан” гэдэг байна. Монгол–ази толиор хөөн үзэхэд японы “шокудоо”, хятадын “шитан” нь манай “хоолны танхим” гэсэн үг болдог байна. Европоор юу болох вэ гэж япон–англи толиор үзэхэд, эртний латин “рестаураре” гэдгээс үүсгэж 1765 онд анх Францад Парист нээсэн “рестран” гэдэг хоолны газрын нэртэй дүйх ажээ. Орос хэлэнд “ресторан” гэдэг нь энгийн хоолны гуанзнаас ялгаатайгаар хэрэглэдэг нэр бөгөөд хоолны газар–столовая гэдэг нь монголоор хоолны гуанз болдог. Үүнд, хүнсний үйлдвэрийнхний жирийн орчуулагч нь столовая бол гуанз гэж мэдэвч, ресторан гэдэг нь юу болохыг утгасудлал /филология/ гэдэг тусгай мэргэжилгүй тул, таарах үг олж үл чадан, арга буюу “рестрандахад” хүрчээ. Гэтэл бичгийн маань хэлэнд 1765 оноос өмнө “хоолны танхим” гэсэн үг, Парист “ресторан” анх нээгдэхээс өмнө байж л дээ!

Японы “шокудоо”-г англиар бас “даинин холл” гэдэг нь холл гэсэн үг нь орос хэлэнд ойрмог үе оржээ. “Шокудоо”-гийн “доо” нь манай танхим гэдэгтэй дүйх учир оросоор “холл” гэдэг даруй манай “танхим” болж байгаа хэрэг. Дайнинхолл гэдэг англи үгийг герман “шпайзезаал” гэдэг, үүнд “заал” гэдэг нь оросоор “зал”, тэхлээр орос “зал” гэдэг нь монголоор бас “танхим” гэдэгтэй дүйх учир, олон улсын нийтийн толийн журмаар гарч ирж байгаа болно.

Европ зүгт монгол–европ толь гарч ирсний анх нь 1844 онд монгол–орос–франц толь бичиг Ковалевский Казан хотноо нийтлэж, одоо хүртэл тэр толь чухлыг алдаагүй учир, гадаадад түүнийг дахин улируулан, саявтар хэвлэсэн байна. Энэ завсар монгол–англи, монгол–франц, монгол–япон зэргийн толь гарчээ. Манайханд орчин үеийн давшилт соёл–шинжлэх ухааны болон улс төр–эдийн засгийн зэрэг мэдлэгийн зүйлд орос хэл маш чухал үүрэг гүйцэтгэн буйн тул, 1942 онд манайхан анх удаа өөрсдөө монгол–орос толь зохион гаргасан билээ. Тэр толийн нооргийг засах үес “окурор” гэдгийг “тамхины иш”, “роза” гэдгийг “сарнай цэцэг” гэж зассаны минь бичээч нь монгол татласан түүнийг “тэмээний сэг, саргай цэцэг” гэж буруу буулгасан нь эрхлээчингүүд нь анзааралгүйгээр, тэр хэвээр нь нийтлэж, 1961 онд гарсан Дамба Ринчинэ, Мункин хоёрын орос–монгол толинд “окурор” гэдгийг “тэмээний” гэдэг нь арай биш байгаа гээд, “тамхины сэг” гэж, “сэг” гэсэн нь “иш” гэснийг буруу хуулсны нь мэдсэнгүй, монгол хэлэнд “сэг” гэж мал адгуусны үхдэлийг хэлэхээс биш, тамхинд сэг гэж байдаггүйг эс мэджээ. 1957 онд Лувсандэндэв монгол–орос толиндоо “сарнай цэцэг” гэдгийг “саргай цэцэг” гэж бичээч нь наагийн цэгийг гаагийн цэг тэмдгээр буруу уншсаныг ухаарсангүй, “саргай цэцэг” л юм байлгүй яахав гэж дагачихсаны нь манай

сургуулийн сурах бичгийн орчуулагч багш нар мөрдөн дагаж, “сарнай цэцгийг” мөн “саргай цэцэг” гэж түмэн сурагчдыг “саргайтуулжээ”. Энэ бол толь бичигт зохиогсон нь маш хариуцлагатай байхын дохио болж байгаа хэрэг.

Хэл зохиолын хүрээлэнгээс н.Дамдинсүрэнгээр эрхлүүлэн н.Лувсандэндэвийг дагалдуулж, Орос–монгол хэлний толь зохиолгосон, үүнд Лувсандэндэвийн хийсэн толгой үсгээс хэдэн хуудас үзэхэд төлөв нуруутай болсон байдалтай байсан билээ. Тэгээд, дээд дэвтэр нь 1967 онд гарахад нь үзвэл, эхний хэдэн үсэгт нь тун хачирхмаар зүйл олон үзэгдлээ. Дээд дэвтэр саявтар хэвлэлээс гарахад сөхөн үзвээс дээд дэвтрийн хачин зүйлийн санаа нь чиг хавсралтын зүйлээс ухагдах байдалтай болж, нийт толийн байдлыг үзвэл, ерөнхий боловсрол, хэлний мэдэцийн хувид эрс тэс өөр боловсролтой хоёр хүн нийлж, дулим боловсролтой хүн нь, давуу боловсролтойгоо “редакторлон” эрхлэсэн нь нүд чичим товойж, толийн чанар дулимхан болсон байна.

Тэр учраас ойр зуурын ярианы үг нь болмоор мэт үзэгдэвч, шинжлэх ухааны утга хэрэгцээ бүхүй зүйлд орос үгийн нарийн утгыг наагуурханаас наагуур, борцуулын ярианы хэмжээгээр ухаараад нарийны нь гаргаж чадаагүй, бас утгасудлал /филология/ гэдэг ухааны мэргэжил мэдэц нимгэдсэн байдал, онол эрдмийн өргөн мэдэц агуулсан орос ном зохиол уншаагүйн шинж, орос үгэнд дүйлгэсэн монгол үгэнд нь хужир сагсайтал ургасан юм шиг үзэгдэж байна. Хэдэн үгийн жишээ авч үзье. Абсолют гэдэг гүн ухааны нэрийг монгол нэр оноохдоо абсолют, туйл, үнэмлэхүй гэжээ. Үнэмлэхүй, үнэмлэхүн гэдэг монгол нэрийг санскрид зэргээр дамжуулан Зөвлөлтийн Ольденбург, Щербатской, Обермиллер зэргийн эрдэмтэн, мөн европын бусад эрдэмтэн магадлан дүйлгэсэн нь латин гаралтай европ абсолюттай таарч байгаа нь аргагүй. Абсолют гэдэг гүн ухааны европ нэрэнд тийнхүү магадласан “үнэмлэхүй” гэдгийг дүйлгэх нь зүй боловч, монгол нэртэй юманд хажуугаар нь бас абсолют гэж хадах нь ямар учиртай вэ? гэдэг нь дээд дэвтрээс мэдэгдэхгүй далд байна. Абсолют гэдэг нэрийг “туйл” гэж бас оноосон нь, тэр абсолют гэдгийн буюу монголоор “үнэмлэхүй, үнэмлэхүн” гэдгийн нарийн утга агуулгыг ухаараагүй наагуурдаж, борцуулын дулим ухааралтаар ухсан байна. Монгол “туйл” гэдэг үгийн утгыг европын, тухайлбал орос хэлний үгээр юу гэсэн болохыг дээр хэдэн хэлний толийн жишээгээр би өгүүлсэн билээ. Абсолютизм гэдгийг тус толинд “хязгаар эрхт засаг, хаант засаг” гэжээ. Улс төрийн хэрэгцээнээ “хязгааргүй эрхт засаг” гэж болно. Хаант засаг гэхдээ болохоо байх нь: хаант засаг гэдгийг орос дүйцэл үг нь “монархия” болдог бөгөөд “хэмжээт эрхт хаант засаг” гэдгийг оросоор “конституционная монархия” гэхээс “конституционный абсолютизм” гэж байдаггүй. Абсолютизм гэдэг латин гаралтай нэр бас христусын шашны дотоод ухаан /оросоор теология/ гэдэгт “хязгааргүй эрхт засаг” гэснээс бас өөр нэгэн утгатай юм. Абсолют гэдгийг үнэмлэхүй гэдэг учир тэр хоёрдугаар утгы нь “үнэмлэхүйн үзэл” гэх учиртай байжээ. Марксист онолч зохиолд түүнийг шүүмжлэсэн зүйл байдгийг энэ толь сөхөн үзэх хүн “хязгааргүй эрхт засаг” гэдгийг л шүүмжлэсэн юм байна гэж төөрөгдөхөд хүрэх нь, толь эрхлээчийн мөчид мэдлэгээс болж бантахад хүрэх нь ээ! Абсолютный гэдэг орос нэрийн жирийн ярианы салбар утгы нь ухааран гаргаад, жинхэнэ шинжлэх ухааны утганд нь ном зохиолы нь судлаагүйн учир хөл алдаж, үнэмлэхүй гэж монгол тохирох үг хадсаны хажуугаар, өөрийнхөө хар ухаанд “туйлын” гэж ордгоо хадсан нь дан ч наагуурджээ. Абсолютная истина гэдгийг “туйлын үнэн” гэж жишээ болгосон нь, “үнэмлэхүй үнэн” гэдгийн утгыг ухаараагүй, “туйлын” гэж буруу ухжээ. Туйлын гэвэл, үнэмлэхийн утгагүй, харицангуйн утгатай, наагуурхан утгатай зүйл: сүзэгтэн хүн, чөтгөр бий гэдэг нь туйлын үнэн! гэж болно. Тэр нь түүний

мэдлэгтэй харьцангуй, тэр хүндээ л үнэн болохоос, үнэмлэхүй үнэн биш шүү дээ! Хоёр гурван градус хүйтэн болдог дулаан оронд арван градус хүйтэн болбол, “туйлын хүйтэн” боллоо гэнэ шүү дээ. Тэхэд, манай энд тэр нь туйлын хүйтэн биш, дөч гарч тавь шахвал, “туйлын хүйтэн” гэхээс арван градусыг “туйлын хүйтэн” гэхгүй шүү дээ. Тэхлээр, тэр “туйлын” гэдэг нь дээр хэдэн толиор хөөн тодорхойлсон – предельный, максимальный гэсэн утгын дотор багтахгаас, “абсолютный” гэдгийн ухагдахуунд хамаагүй, үнэмлэхүйн биш, харьцангуйн утгатай үг болно. Бас жишээлбэл, орос хэл мэдэхгүй буюу ганц нэг үг мэддэг хүний дэргэд н.Дамдинсүрэнгийн орос хэлний мэдэц нь “туйлын сайн” байж болно. Гэтэл, жинхэнэ оросч эрдэмтний дэргэд “туйлын сайн” мэддэг нь биш болж, маш харьцангуй болохоос, үнэмлэхүй сайн биш болчихно шүү гэдгийг энэ толиороо хүртэл үзүүлж байна шүү дээ!

Бог гэдгийг тэнгэр, бурхан гэж оноожээ. Борчуулын ухааралтаар зөв. Богиня гэдгийг охин тэнгэр, лхамо, дар эх гэжээ. Гэтэл, бурхан гэдгийг төвдөөр санжай гэхээс лха гэдэггүй. Монголоор бурханы шажин гэдгийг оросоор христианство гэдэггүй, буддизм гэдэг. Учир нь манай бурхан гэдгийг санскридаар буддха, европын бүх хэлнээ будда гэдэг. Библи судрын монгол орчуулганд Бог гэдэг орос нэр, латины Деус, санскридын Дева, төвдийн Лха, францын Дьё, германы Готт гэдэгтэй дүйдэг нэр. Монголоороо Дивангар бурхан, Шигемуни бурхан гэхээс Дивангар лха, Шигемуни лха гэдэггүй нь монголоор ч гэсэн бурхан тэнгэр хоёр харилцан ялгаатайг үзүүлж байгаа хэрэг. Данте Аллигиерийн нэрт зохиол Дивине Комедие гэдгийг оросоор “Божественная комедия” гэхээс “Буддийская комедия” гэж орчуулдаггүйг бид ч гэсэн “Тэнгэрлэг жүжиг” гэхээс “Бурханлаг жүжиг” гэдэггүйд учир бий шүү дээ! Марксизмын сонгодог зохиолд Будда гэсэн бурханыг өгүүлдэггүй, бог–тэнгэр гэдэг шашны гол утгаар нь шүүмжлэн бичдэг зүйлийг үзэх орчуулахад бурхан гэж төөрөгдүүлэх энэ толь бол, зүйрлэхэд скот гэснийг мал гэлгүй “ямаа” гэж оноосонтой адил. Ямаа нь мал боловч, мал бүхэн ямаа биш шүү дээ. Гурван сайн заяа гэж бурханы шашин /оросоор Буддизм/ гэдэгт хүн, тэнгэр, асури гэж, хүн нь бурхан биш, тэнгэр нь бурхан биш, асури нь бурхан биш гэж үздэг, үүнд орос шинжилгээний зохиол түүнийг “люди, боги и асурий” гэж оноон орчуулдаг байгаа учрыг эс мэджээ! Богиня гэж охин тэнгэр мөн, лхамо ч гэж төвдөөр нэрлэдэг нь мөн, санскридаар дева гэдэгтэй дүйдэг билээ. Тэхэд, богиня гэдгийг дагина гэж арай л биш, энэтхэгийг дакини гэдгийг монголоор дагини, оросоор дакини, дакинисса гэж ном зохиолд байдаг бөгөөд дар эх гэж хорин нэгэн Дар нэртэй Цагаан Дар эх, Ногоон Дар эх гэдэг нь охин тэнгэр болгон дар эх биш гэдгийг Лхамыг Дар эх гэдэггүй, Нар хажидийг Дар эх гэдэггүйгээс монгол хэлэнд илэрхий бөгөөд орос хэлнээ Дар эхийг богиня Тара гэж богиня гэдгийн нэгэн зүйл богиня Минерва-Минерва охин тэнгэр, богиня Афродита–Афродит охин тэнгэр гэсэн шиг нэгэн зүйл “богиня” болохоос, богиня болгон “дар эх” биш! Ангел гэдгийг бас сахиулсан тэнгэр гэж оноосон нь, сөрөгөөр /тэнгэрийн/ элч гэсний нь огт мэдсэнгүй. Харин хар бор ярианд өхөөрдөж хэрэглэдгий нь “хонгор” гэж ухааран оноогоод цаад нарийн учир дээр нь хөл алдсан нь, нарийн зүйл бүхэнд ингэж мэдэц нимгэнээ илтгэжээ.

Бегемот гэдгийг армана гэж зөв оноосон боловч, усны үхэр гэж бас хадсанаараа адгуусны судлалын зүйлд дунд сургуулийн сурах бичгийн зүйл ч сөхөөгүй нь харамсалтай. Бүх монгол толинд армана, усны үхэр хоёрыг ялгасаар ирж, Цэвэлийн товч тайлбар толинд усны үхрийг: бие том, эвэр урт, үс тачир, усанд хэвтэх дуртай, хүч маш их нэг зүйл үхэр, эврий нь нум хийхэд хэрэглэнэ гэсэн байдаг. Дамдинсүрэн,

арманыг үхэр болгоод, үс эвэр ургуулж амьтны судлалд шинэ нээлт хийсэн нь, амьтан судлалын тухай дунд сургуулийнхаа сурах бичиг үзвэл, арай тэхгүйсэн байх! Усны үхэр бол, оросоор буйвол гэдэг юм.

Гиена гэдгийг чононцор гэжээ! Гэтэл монгол толинд гиена гэдгийг ийнэ гэдэг нь латин хэлнээс XII зууны үед францад хиене гэж орсон тэр нэр, орос хэлэнд х үсгий нь г болгож гиена гэдэг болсныг монголд х үсгийг үл дуудах франц аялгуугаар дамжин ийнэ гэдэг нь арван наймдугаар зууны монгол-нангиад-манж-төвд-хотон таван хэлний толинд гэрчлээстэй бөгөөд манж нар, латины нь дагаж хиена гэж авсан үүнд, монгол нэр нь нийт герег-латин болон бүх европын нэртэй нь гарал холбоо нэгтэй байтал, амьтны судлалын тухай дундад боловсролын мэдэцгүйгээ илчлэж, чононцор гэж таамаглажээ.

Химийн нэрийн зүйлд бас л дундад сургуулийн сурах бичигт байдаг хэмжээнд хүрээгүйн байдал үзүүлж, азотистый гэдгийг азотлог, азоттой гэж хоёр ац нэр оноосон нь, химид валентность буюу манай нэр томьёонд цэнчанар гэсэн нэр бүхүй зүйл маш чухал үүрэг гүйцэтгэж, химийн бүх эд махбодийг атомын цэнчанараар нь ялган ангилж, орчин үеийн улсын хэл болгонд тусгай дагавар оноон тогтоож, түүгээрээ цэнчанары нь заан үзүүлдэгийг мэдэлгүйгээр, -стый гэж орос химийн нэрнээ тогтмол хэрэглэдгийг монгол химийн нэрэнд мөн тогтмол ганцхан –тай гэдгээр заан илэрхийлдэг ёсыг огт мэдээгүйгээрээ хими мэдэхгүй орчуулагчийг хөглүүлж, орчин үеийн дунд боловсролтой хүнд элэг болох нь болжээ.

Монгол үгэндээ хүнжид гэдгийг гүнжид гэж тааж, соносоогүй үгээ хазгай дууддаг, бас монгол үгний нэр үйл үг бүтээх дагаврын зүй зарчмыг мэддэггүйн учраас зябрь гэдгийг “цэвдэгш” гэж шал буруу зохиомол муухай үг оруулсан нь нэр үгнээс нэр үг бүтээхэд ер –ш дагавар ордог ёс монгол хэлэнд байдаггүйг мэдээгүй нь өрөвдөм харамсалтай бөгөөд түүний амаар будаа идэх нимгэн боловсролтон орчуулагч уншигчдыг төөрөгдүүлэх нь хөөрхийлэлтэй ажээ.

Энэ мэтийн тун харамсалтай дутагдлыг бүгдий нь тоочих юм бол, тус толийн гуравдугаар дэвтрийн дайтай юм болох тул, энэ хэдэн жишээгээр байдлы нь тодорхойлж болох бөгөөд сайн толийг цолоор хийдэггүй, эрдэм мэдлэгээр хийдэг юм байна гэдгийг энэ шаазгай алаг толь давтан батласны нь тэмдэглүүштэй байна.

Бас нэгэн зүйлийг дурдвал, тус толинд монгол нэр байсаар байтал, давхар гадаадын үг шаадаг нь эхний дэвтэрт буй учир ухагдахгүй байснаа сүүлийн дэвтрийн хавсралт болгосон зориулалт зүйлээс далдын санаа нь ил болох шиг үзэгдэж байна.

Орчин үеийн толийн зарчимд өөрийнхөө бичгийн хэлэнд байдаг үгийн хажуугаар боловсрол нимгэн борцуул давхаргын үг, тэдний илүү дутуу хэрэглэдэг гадаадын үг оруулдаг ёсгүй билээ. Хэрэгцээгүй гадаадын үг илүүц үл хэрэглэхийг Ленин тусгайлан нэгэн маш оновчтой бөгөөд бяцхан өгүүлбэр бичсэн нь энэ тухай бидэнд мөн чухал заалт болох ёстой. Орчин үеийн орос хэлний толинд орос бичгийнхээ хэлэнд орсон үгийн хажуугаар өөр улсын үг хэрэгцээгүй оруулж, жишээ нь бегемот гэдгийнхээ хажууд нь германы Нилпферде буюу унгарын Визилоо хэрэглэ гэж хаддаггүй. Апельсин гэдэг нэр орос хэлэнд орсон байхад, оранж гэж франц нэр хадах буюу, польшоор помыранча гэдгийг орос үгэндээ хэрэглэ гэж хаддаггүй байхад тус толинд арманын хажуугаар бегемот, хаягийн хажуугаар адрес гэх зэргээр монгол үгээ байсаар байтал, заавал гадаадын үг хадаастай байхы нь үзэхэд н үсэгт нос гэдгийг хамар гэж оноохынхоо хажуугаар ноос гэж хадсан байгаа бол уу? гэж санагдмаар үзэгдэл дүүрэн байна. Харь хэлэнд айдрис, апилсийн гэж хэрэглэж магадгүй юм. Тос гэдгээ ч маасал,

сүү гэдгээ ч молкоо гэж магадгүй. Сибирийн орос аман аялгуунд коза гэдгийг яман, штаны гэдгийг үмүдүн, ведро гэдгийг хубин, чесотка гэдгийг хамун, перевал гэдгийгээ дабан гэж монгол үг хэрэглэн заншсан боловч, орос бичгийнхээ хэлэнд тэдгээр “гадаад” үгийг оруулдаг зарчимгүй нь нийтийн журам. Тэхэд, монгол үгнийхээ байсаар байтал илүүц гадаадын үг оруулж орхисон нь, одоо тэхээс өөр аргагүй бол гэсэн юм шиг үзэгдэж, сүүлийн дэвтрийн дагавар хавсралт нь тэр санааг бүр ч лавшруулсан юм шиг байна.

Энэ толь нь гарсанаар орос–монгол орчин үеийн сайн толийн хэрэгцээ огт хангагдаагүй, харин ч улам шаардлагатай болсон тул, шаазгай алаг энэ толиос санаа авч, ойрын хэдэн жилд хаа ч нүүр улайлгахгүй сайн толь хийх нь тун чухал болж байна.

Манай хэвлэл, тус толь хэвлэсэн байдлаараа сайн толь зохиох л юм бол, хэвлэхийн дайтай хэвлэж чадна гэдгээ үзүүлсэн байна. Түүнд нь баярлалтай байна.

Ринчен доктор

Өөрийн нь бичсэн эхээс нь сийрүүлэв. Улаан тосон балаар найруулгыг засажээ. 1970 оны III сарын 17 гэж үдэх зайнд нь бичжээ².

² Төгсгөлд манжич Ц.Шархүү багшийн тэмдэглэснийг ташуу үсгээр буулгав.